

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

___ оны ___ сарын ___ өдөр

Улаанбаатар хот

Зааварт өөрчлөлт оруулах тухай

Галт зэвсгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/72 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтын заавар”-ын Дөрөвдүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/“Дөрөвдүгээр зүйл.Суралцагчид тавигдах шаардлага

4.1.Сургалтад хамрагдах иргэн, хуулийн этгээдийн ажилтан дараах баримт бичгийг төрийн үйлчилгээний нэгдсэн системээр бүрдүүлнэ. Үүнд:

4.1.1.Иргэн дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

- иргэний үнэмлэхийн лавлагаа;
- оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа, тодорхойлолт;
- галт зэвсэг ашиглахад харшлах өвчин, гэмтэл согогийн жагсаалтад заасан өвчин, эмгэггүйг тодорхойлсон эрүүл мэндийн хуудас;
- төлбөр төлсөн баримт.

4.1.2.Харуул хамгаалалтын болон спорт сургалтын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд ажилтнаа сургалтад хамруулахдаа дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

- сургалтад хамруулах тухай хүсэлт;
- харуул хамгаалалтын болон спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн лавлагаа;
- гэрээт харуул хамгаалалтын сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар.

4.2.Галт зэвсгийн сургалтад хамрагдсаныг нотлох дараах баримт бичигтэй иргэнд Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв нь галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтын гэрчилгээг олгож болно. Үүнд:

4.2.1.Галт зэвсгийн сургалтад хамрагдсаныг нотлох баримт бичигтэй иргэн дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

а)Буудлага спортын холбооны тодорхойлолт (Буудлага спортын холбооны улсын бүртгэлд бүртгүүлсэн гэрчилгээний лавлагаа, тодорхойлолт, албан хүсэлт);

б)цэрэг, цагдаагийн сургууль (галын бэлтгэлд хамрагдсан) төгсөж, олгосон баримт бичиг, түүний хавсралт;

в)зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тусгай албадын үндсэн чиг үүрэг гүйцэтгэдэг алба хаагчид олгосон албан байгууллагын тодорхойлолт;

г)гэрээт харуул хамгаалалтын сургалтад хамрагдсаныг нотлох гэрчилгээг тус тус бүрдүүлэхээс гадна энэ зааврын 4.1.1-д заасан баримт бичгийг бүрдүүлсэн байна.

4.3.Сургалтаас чөлөөлөгдөж сургалтын гэрчилгээ авах иргэн “Сургалтын төлбөрийн хэмжээ, зардлын норматив батлах тухай” дотоод хэргийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан шийдвэрт заасан тарифын дагуу гэрчилгээний үнийг төлнө.”.

2.Тушаалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (бригадын генерал Ц.Ням-Очир)-д даалгасугай.

4.Тушаалыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Т.СҮХБОЛД